



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар Д/61

Баян-Овоо сум

Багш, ажилчдад ур чадварын
нэмэгдлийг олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт (төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам)-ын 2,3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан А/35, А/10, 9 дүгээр тушаалын 3.1, 6, 8 дахь заалт, Хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж багшлахуй суралцахуй үйлийг бүтээлчээр хэрэгжүүлэн, суралцагчдыг хөгжүүлэх төлөвшүүлэх үйлд хариуцлагатай санаачилгатай ажиллаж, хагас жилийн үнэлгээгээр хангалттай дүгнэгдсэн багш, ажилчдад ур чадварын нэмэгдлийг олгосугай.

2. Багш, ажилчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Ур чадварын нэмэгдлийг хавсралтад заасны дагуу 9 дүгээр сараас эхлэн сар бүр олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Ч.БОЛОРМАА